



1925

**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2024.08.30 № 1/1344
танай _____-ны № _____-т

Тодруулга өгөх тухай

Тус эмнэлгээс зарласан ЭМЯ/20240102047 дугаар бүхий тендерийн баримт бичгээс тендерт оролцогч компани тодруулга авах хүсэлтийг ирүүлсний дагуу дараах тодруулгын хариуг өгч байна. Үүнд:

Асуулт:

1. “Бараа нийлүүлэлтийн хуваарийг тендерийн баримт бичгийн бараа нийлүүлэх хуваарьт “гэрээ байгуулснаас хойш 3 сар” гэж заасан байна. Дэлхийн бүх үйлдвэрлэгч нарын хувьд MRI буюу Соронзон резонанст томографийн аппаратыг ямар ч тохиолдолд бусад эмнэлгийн тоног төхөөрөмжтэй адил урьдчилж үйлдвэрлэх боломжгүй байдаг. Учир нь тухайн аппарат

- Өртөг өндөр
- Гелийн цэнэглэлтийн технологиос хамаарч агуулахад хадгалах боломжгүй
- Тухайлсан төсөл, хөтөлбөрт зориулан зах зээлд шинээр үйлдвэрлэгдэж гардаг болно.

Мөн үйлдвэрлэгдэх хугацаа дэлхийн үйлдвэрлэгч нарын хувьд технологийн ялгаатай байдлаас шалтгаалан дунджаар 160-180 хоног байдаг бөгөөд ялангуяа Гелитэй MRI аппаратын хувьд үйлдвэрлэлийн процесс дээр дурдсанаас бага байх боломжгүй юм. Иймд тендерийн үндсэн техникийн шаардлагад нөлөөлөхгүй ханган нийлүүлэгчдээс үл хамаарсан дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж нийлүүлэлтийн хугацааг сунгах боломжтой эсэх эсвэл тендерт шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах үед уг бараа нийлүүлэх хугацааг өөрчлөн тохиролцож болох эсэх талаар тодруулга хийж өгнө үү.

Хариулт:

Тендерт шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах үед уг бараа нийлүүлэх үйлдвэрлэгчийн албан бичгийг үндэслэн хугацааг өөрчлөн тохиролцох боломжтой.

002357

Асуулт:

1. Тендерийн бичиг баримтын техникийн тодорхойлолтын 16. Соронзон орны хамгаалалттай шинжилгээний өрөөний иж бүрэн засвар хэсэгт аппарат суурилуулах өрөө нь 23,94 м² гэж заасан байх бөгөөд тус өрөөний засварын ажилтай холбоотойгоор эмнэлгийн соронзон резонанст томографийн аппарат суурилуулахаар төлөвлөж буй /очиж танилцахад/ өрөөний хэмжээ бодитоор 23,06 м² байна. Гэтэл дэлхийн үйлдвэрлэгчдийн 1,5Т хүчин чадалтай соронзон резонанст томографийн аппарат суурилуулах өрөөний дундаж стандарт зай талбай нь 25 м²-аас багагүй байхаар заагдсан байдаг. (Дэлхийн үйлдвэрлэгчдийн Соронзон резонанст томографийн аппарат суурилуулах өрөөний хэмжээг доорх зургаас харна уу). Учир нь тус аппаратын хувьд соронзон орны тархалтын зөвшөөрөгдөх хязгаар гэж онцлог үзүүлэлт байдаг бөгөөд дээр дурдсан буюу 25 м² –аас бага зай талбайд суурилуулах тохиолдолд өрөөний соронзон орны хамгаалалтыг хийх нь анхны өрөөний хэмжээ мөн багасаж, аппарат суурилуулах боломжгүй болох юм. Өөрөөр хэлбэл аппарат хана хоорондын зай ойр байх тусам соронзон орон бага зайд үүсэж байгаагаас шалтгаалж соронзон орны хамгаалалтыг илүү зузаатгах (ханыг зузаатгах) шаардлага тулгарах ба ингэснээр өрөөний зай талбай дахин багасаж байгаа юм.

Иймд тус тендерт шалгарсан тохиолдолд аппарат суурилуулах өрөөг Соронзон резонанст томографийн аппарат суурилуулах дэлхийн дундаж стандартад нийцэхүйц зай талбайтай өрөөгөөр сольж шийдвэрлэх боломжтой эсэх дээр бидэнд тодруулга өгнө үү.

Хэрэв аппарат суурилуулах өрөөг сольж шийдвэрлэх боломжгүй тохиолдолд техникийн тодорхойлолтод заасан аппарат суурилуулах өрөөг суурилуулалтын өмнө иж бүрэн засварыг хийж соронзон томографийн өрөөний стандартын хамгийн бага хэмжээгээр өргөтгөн засварлах буюу ханын зузааныг багасгах боломжтой эсэх дээр бидэнд тодруулга өгнө үү. Учир нь төлөвлөж буй өрөөний хана маш зузаан байгаа бөгөөд ханын бүтээцээс шалтгаалж, өрөөний зай талбайг томсгож болох эсэхийг баталгаажуулах бүрэн боломжтой байгаа тул техникийн тодорхойлолтод заасан өрөөнүүдийн барилга бүтээцийн зургийг тендерт оролцохоор сонирхогчдод өгөх боломжтой эсэх талаар бидэнд мөн тодруулга хийж өгнө үү.

Хариулт:

Соронзон резонанст томографийн аппарат суурилуулах өрөөг солих боломжгүй бөгөөд удирдлагын өрөө тал руу 1 метр сунгах боломжтой гэсэн тайлбарыг өгч байна.

Хавсралтаар өрөөний Барилга бүтээцийн зургийг хүргүүлж байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ХИШИГЖАРГАЛ

PROJEKTOWANIE I WYKONANIE PRAC
BUDOWLANYCH W ZAKRESIE
BUDOWY I REMONTU BUDYNKÓW
MIESZKANIOWYCH I GOSPODARSTWA
KOMUNALNEGO
KONSTRUKCJA I WYKONANIE PRAC
BUDOWLANYCH W ZAKRESIE
BUDOWY I REMONTU BUDYNKÓW
MIESZKANIOWYCH I GOSPODARSTWA
KOMUNALNEGO

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59	60	61	62	63	64	65	66	67	68	69	70	71	72	73	74	75	76	77	78	79	80	81	82	83	84	85	86	87	88	89	90	91	92	93	94	95	96	97	98	99	100
---	---	---	---	---	---	---	---	---	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	-----

